

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	14
3.Аудитын тайлан.....	15
3.1. Ерөнхий зүйл.....	15
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	15
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	16
3.4. Материаллаг байдал	16
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	17
3.7. Шилэн дансны мэдээлэл	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.9. Аудитын илрүүлэлт.....	18
Залруулсан алдаа	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	19
Аудитын зөвлөмж.....	19
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	19
4. Менежментийн захидал	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.02.25 № 04/552
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Богд хааны ордон музейн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Богд хааны ордон музейн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Богд хааны ордон музейн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт 50 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлийг 97.5 хувьтай тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	387,374,360.30	385,139,412.10
33	АВЛАГА	27,935,176.00	66,986,351.80
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	154,400.80
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	12,951,400.00	14,017,500.00
335	Бусад авлага	13,476,551.00	52,814,451.00
3351	Байгууллагаас авах авлага	13,476,551.00	52,814,451.00
34	УРЬДЧИЛГАА	101,358,200.00	83,430,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	101,358,200.00	83,430,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	258,080,984.30	234,723,060.30
351	Түүхий эд материал	140,700.00	195,300.00
35130	Эм боох материал	140,700.00	195,300.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	12,564,000.00	12,384,000.00
354	Хангамжийн материал	245,376,284.30	222,143,760.30
35410	Бичиг хэргийн материал	9,420,706.00	9,543,296.00
35420	Аж ахуйн материал	85,699,033.30	78,712,333.30
35440	Түлш, шатах тослох материал	-	141,000.00
35470	Бусад хангамжийн материал	150,256,545.00	133,747,131.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	17,534,708,414.40	17,708,283,687.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	17,534,708,414.40	17,708,283,687.90
392	Биет хөрөнгө	16,422,494,214.50	16,292,933,187.30
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,028,891,829.30	2,028,891,829.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	(572,189,348.30)	(655,597,437.60)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	20,077,777.80	20,077,777.80
39204	Хуримтлагдсан элэгдэл	(20,077,777.80)	(20,077,777.80)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	337,747,098.40	337,747,098.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(216,789,624.10)	(253,457,973.60)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	200,244,624.40	200,244,624.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(158,736,709.10)	(168,646,297.50)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	14,785,597,927.90	14,785,597,927.90

39217	Ном	17,728,416.00	18,153,416.00
393	Биет бус хөрөнгө	1,112,214,199.80	1,415,350,500.60
39301	Програм хангамж	20,740,000.00	20,740,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,884,000.20)	(7,314,000.10)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,097,358,200.00	1,401,924,500.70
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	17,922,082,774.70	18,093,423,100.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,193,446.60	1,575,564.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,193,246.60	1,575,564.00
413	Өглөг	2,686,021.60	1,575,564.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,686,021.60	1,575,564.00
4136	Бусад өглөг	1,507,225.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	1,507,225.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	200.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	17,917,889,328.10	18,091,847,536.00
51	Засгийн газрын хувь оролцоо	17,917,889,328.10	18,091,847,536.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,382,378,312.90	4,686,944,613.60
51101	Өмч: - төрийн	4,382,378,312.90	4,686,944,613.60
512	Хуримтлагдсан үр дүн	55,653,815.90	(74,954,276.80)
51210	Өмнөх үеийн үр дүн	55,514,727.90	55,653,815.90
51220	Тайлант үеийн үр дүн	139,088.00	(130,608,092.80)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	13,479,857,199.20	13,479,857,199.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	17,922,082,774.70	18,093,423,100.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	840,305,206.00	501,862,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	840,305,206.00	501,862,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	448,867,700.00	428,314,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	448,867,700.00	428,314,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	391,437,506.00	73,547,700.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	50,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	381,437,506.00	23,547,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	840,166,118.00	632,470,092.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	840,166,118.00	632,470,092.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	806,118,875.70	596,943,632.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	238,987,941.40	231,200,591.80
210101	Үндсэн цалин	238,987,941.40	162,682,076.80
210102	Нэмэгдэл	-	54,014,515.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	14,504,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,606,038.30	31,375,804.70
210201	Тэтгэврийн даатгал	21,068,858.30	21,712,232.60
210202	Тэтгэмжийн даатгал	2,384,295.00	2,428,493.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,907,436.00	1,929,574.40
210204	Ажилгүйдлийн даатгал	476,859.00	482,118.60
210205	Эрүүл мэндийн даатгал	4,768,590.00	4,823,386.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,599,002.40	33,393,029.30
210301	Гэрэл, цахилгаан	20,431,475.00	17,441,138.00
210302	Түлш, халаалт	16,863,421.60	14,145,833.80
210303	Цэвэр, бохир ус	1,304,105.80	1,806,057.50
2104	Хангамж, бараа материалын зардал	179,634,561.70	81,732,429.60
210401	Бичиг хэрэг	8,821,240.00	3,438,609.00
210402	Тээвэр, шатахуун	3,631,246.00	2,767,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,286,786.00	1,797,625.60
210404	Ном, хэвлэл	27,216,786.00	19,275,490.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,699,080.00	5,314,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	94,637,641.00	39,401,505.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	31,202,585.00	9,737,700.00
210408	Бараа материал акталсны зардал	9,139,139.00	0.00
2105	Нормативт зардал	361,225.00	445,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	109,100.00	445,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	252,125.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,895,000.00	2,358,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,835,000.00	1,092,000.00
210604	Урсгал засвар	6,060,000.00	1,266,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	151,057,268.80	85,022,350.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	126,302,368.80	68,168,230.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	9,900,000.00	9,900,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	497,500.00	223,720.00
210807	Газрын төлбөр	7,116,900.00	5,050,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5,740,500.00	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	148,943,638.10	131,416,027.20

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	148,943,638.10	131,416,027.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,047,242.30	35,526,460.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,900,000.00	410,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,900,000.00	410,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	30,147,242.30	35,116,460.30
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,147,242.30	34,413,640.30
213305	Нэмэлт санхүүжилтийн дансны төвлөрүүлэх шилжүүлэг	-	702,820.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>139,088.00</u>	<u>(130,608,092.80)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>139,088.00</u>	<u>(130,608,092.80)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>870,684,827.00</u>	<u>500,796,200.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	870,684,827.00	500,796,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	448,867,700.00	428,314,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	448,867,700.00	428,314,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	421,817,127.00	72,481,900.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	40,342,021.00	50,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	371,475,106.00	22,481,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>820,407,192.60</u>	<u>500,371,200.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	820,407,192.60	500,371,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	794,130,428.70	464,844,739.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	235,870,640.70	231,903,411.80
210101	Үндсэн цалин	154,700,610.70	163,384,896.80
210102	Нэмэгдэл	34,338,312.00	54,014,515.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,283,000.00	14,504,000.00
210104	Урамшуулал	32,548,718.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,549,189.90	31,553,046.10
210201	Тэтгэврийн даатгал	22,177,889.90	20,365,831.80
210202	Тэтгэмжийн даатгал	2,092,800.00	3,952,135.20
210203	ҮМШОӨ-ний даатгал	1,674,300.00	1,929,574.40
210204	Ажилгүйдлийн даатгал	418,600.00	482,118.60
210205	Эрүүл мэндийн даатгал	4,185,600.00	4,823,384.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,599,002.40	33,393,029.30
210301	Гэрэл, цахилгаан	20,431,475.00	17,441,138.00
210302	Түлш, халаалт	16,863,421.60	14,145,833.80
210303	Цэвэр, бохир ус	1,304,105.80	1,806,057.50
2104	Хангамж, бараа материалын зардал	70,319,123.70	21,662,925.60
210401	Бичиг хэрэг	7,539,800.00	2,098,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,031,246.00	2,558,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,586,844.70	2,097,625.60
210404	Ном, хэвлэл	37,846,650.00	825,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,699,080.00	5,314,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,615,503.00	8,769,800.00
2105	Нормативт зардал	10,884,000.00	4,251,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,884,000.00	4,251,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	99,208,585.00	8,691,980.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,271,885.00	1,338,000.00
210604	Урсгал засвар	92,936,700.00	7,353,980.00

2107	Томилолт, зочны зардал	10,967,000.00	0.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	10,967,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	297,732,887.10	133,389,347.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	269,718,487.10	116,602,347.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	9,900,000.00	9,900,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	497,500.00	336,600.00
210807	Газрын төлбөр	7,116,900.00	5,050,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	9,000,000.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,276,763.80	35,526,460.30
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,000,000.00	410,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.00	410,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,276,763.80	35,116,460.30
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,276,763.80	34,413,640.30
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг		702,820.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>50,277,634.40</u>	<u>425,000.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	0.00	0.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	40,906,665.00	425,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	40,906.665.00	425,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	40,906,665.00	425,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	40,906,665.00	425,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(40,906,665.00)</u>	<u>(425,000.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>0.00</u>	<u>0.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(6,734.00)	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,734.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,382,378,312.90	13,479,857,199.20	55,514,727.90	17,917,750,240
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C07	Тайлант үеийн үр дүн			139,088.00	0.00
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,382,378,312.90	13,479,857,199.20	55,653,816.00	17,917,889,328.10
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,382,378,312.90	13,479,857,199.20	55,653,816.00	17,917,889,328.10
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	304,566,300.7	0.0	0.00	304,566,300.70
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(130,608,092.80)	(130,608,092.800)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,686,944,613.60	13,479,857,199.20	(74,954,276.80)	18,091,847,536.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	438,626,900.00	393,900,659.70	(44,726,240.30)	89.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	438,216,900.00	393,900,659.70	(44,726,240.30)	89.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	438,216,900.00	393,490,659.70	(44,726,240.30)	89.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	242,509,000.00	231,903,411.80	(10,605,588.20)	95.6
210101	Үндсэн цалин	162,154,400.00	163,384,896.80	1,230,496.80	100.8
210102	Нэмэгдэл	64,478,600.00	54,014,515.00	(10,464,085.00)	83.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,876,000.00	14,504,000.00	(1,372,000.00)	91.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,738,600.00	31,553,046.10	(1,185,553.90)	96.4
210201	Тэтгэврийн даатгал	23,038,200.00	21,889,474.00	(1,148,726.00)	95.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,425,100.00	2,428,493.00	3,393.00	100.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,940,100.00	1,929,574.40	(10,525.60)	99.5
210204	Ажилгүйдлийн даатгал	485,000.00	482,118.60	(2,881.40)	99.4
210205	Эрүүл мэндийн даатгал	4,850,200.00	4,823,386.00	(26,814.00)	99.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,731,200.00	33,393,029.30	(11,338,170.80)	74.7
210301	Гэрэл, цахилгаан	20,046,000.00	17,441,138.00	(2,604,862.00)	87.0
210302	Түлш, халаалт	21,772,000.00	14,145,833.80	(7,626,166.20)	65.0
210303	Цэвэр, бохир ус	2,913,200.00	1,806,057.50	(1,107,142.50)	62.0
2104	Хангамж, бараа материалын зардал	14,636,000.00	14,349,025.60	(286,974.40)	98.0
210401	Бичиг хэрэг	2,098,000.00	2,098,000.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	1,708,400.00	1,708,100.00	(300.00)	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,034,900.00	2,097,625.60	62,725.60	103.1
210404	Ном, хэвлэл	459,700.00	425,000.00	(34,700.00)	92.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,900,800.00	3,586,100.00	(314,700.00)	91.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,434,200.00	4,434,200.00	-	100.0
2105	Нормативт зардал	1,432,800.00	1,432,800.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,432,800.00	1,432,800.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,338,000.00	1,338,000.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,338,000.00	1,338,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	100,831,300.00	79,521,347.00	(21,309,953.00)	78.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	83,139,300.00	62,734,347.00	(20,404,953.00)	75.5
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	9,900,000.00	9,900,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	85,000.00	-	(85,000.00)	-

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	336,600.00	336,600.00	-	100.0
210807	Газрын төлбөр	5,050,400.00	5,050,400.00	-	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	820,000.00	-	(820,000.00)	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	410,000.00	410,000.00	-	100.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-	-	
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг			-	
2132	Бусад урсгал шилжүүлэг	410,000.00	410,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	410,000.00	410,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	438,626,900.00	393,900,659.70	(44,726,240.30)	89.8
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	438,626,900.00	393,900,659.70	(44,726,240.30)	89.8
131001	Улсын төсвөөс санхүүжих	438,626,900.00	393,900,659.70	(44,726,240.30)	89.8
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0,00	0,00	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	22	22	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	-
610001	Төсвийн байгууллага	1	1	-	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21	21	-	-
620001	Удирдах ажилтан	1	1	-	-
620002	Гүйцэтгэх ажилтан	11	11	-	-
620003	Үйлчлэх ажилтан	9	9	-	-
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ			-	

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		72,481,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		71,779,080.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		71,779,080.00
2104	Хангамж, бараа материалын зардал		7,738,900.00
210402	Тээвэр, шатахуун		850,000.00
210404	Ном, хэвлэл		825,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		1,728,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		4,335,600.00
2105	Нормативт зардал		2,818,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		2,818,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		7,353,980.00
210604	Урсгал засвар		7,353,980.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		53,868,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		53,868,000.00
26	ТӨВЛӨРҮҮЛЭХ ШИЛЖҮҮЛЭГ		702,820.00
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг		702,820.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		72,481,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		72,481,900.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		50,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		22,481,900.00
12000	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Богд хааны ордон музейн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Богд хааны ордон музейн захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Эрдэнэбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, автомашины сэлбэг сольсонтой холбоотой техникийн паспорт бөглөх, и баримтаар баталгаажсан анхан шатны баримтын бүрдэл гүйцэд баримтаар гүйлгээ хийх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 26-наас 2021 оны 02 дугаар сарын 15-ны хооронд “Гэрэлт хөхийн тэнцвэр аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Богд хааны ордон музейн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 008 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Богд хааны ордон музейн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Түүхэн дэс дараалал, бүтцийн нэгдмэл шинж бүхий үзүүллэгтэй музейн байнгын үзүүллэгийн агуулга, бүтцийн чиглэлийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална. Хэсэгчилсэн өөрчлөлт дэглэлтийг удирдах байгууллагын баталсан удирдамжийн дагуу гүйцэтгэнэ.
- Үзүүллэгийг шинжлэх ухааны үндэслэлтэй, уран сайхны зохистой шийдэлтэй, шинэ мэдээлэл багтаан, тогтмол баяжуулан шинэчлэн дэглэнэ.
- Сан хөмрөгөө төлөвлөгөөтэй байнга баяжуулж, иж бүрдүүлэх, эрэн сурвалжлах, хайгуул цуглуулгын ажлыг зохион байгуулна.
- Сан хөмрөгийн тохирсон нөхцөлийг бүрдүүлж, хадгалж хамгаалах, сэргээн засварлах ажлыг зохих журмын дагуу гүйцэтгэнэ.
- Үзмэр, эд зүйлийг бүртгэн баримтжуулах, үзлэг, тооллого явуулах, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг зохих журмын дагуу гүйцэтгэнэ.
- Музейн үзмэрт түшиглэн судалгаа шинжилгээний ажлыг дангаар болон холбогдох эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран явуулж, үр дүнг нийтийн хүртээл болгоно.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Ковид-19 цар тахалтай холбоотой засгийн газрын тогтоол, шийдвэрүүд

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Богд хааны ордон музей нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 632,470.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,324.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Богд хааны ордон музейн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 171,340.3 мянган төгрөгөөр буюу 1.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дансуудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	27,935.2	66,986.4	39,051.2
Урьдчилгаа	101,358.2	83,430.0	-17,928.2
Бараа материал	258,081.0	234,723.1	-23,357.9
Үндсэн хөрөнгө	16,422,494.2	16,292,933.2	-129,256.0
Биет бус хөрөнгө	1,112,214.2	1,415,350.5	303,136.3
Нийт хөрөнгө	17,922,082.8	18,093,423.1	171,340.3
Өр төлбөр	4,193.5	1,575.6	-2,617.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	17,917,889.3	18,091,847.5	173,958.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	17,922,082.8	18,093,423.1	171,340.3

Авлага дансны үлдэгдэл 66,986.3 мянган төгрөг болж 39,051.2 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны авлагыг бүрэн барагдуулаагүйтэй холбоотой. Тайлант хугацаандаа ажилчидтай холбоотой 154.4 мянган төгрөгийн авлага, төлбөрт үйлчилгээтэй холбоотой 14,017.5 мянган төгрөгийн авлага, байгууллагаас авах 52,814.4 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 83,430.0 мянган төгрөг болж 17,928.2 мянган төгрөгийн өртөг бүхий наймдугаар богд Жавзандамба хутагтыг монгол оронд залсан нь архивын баримт бичгийн судалгааны ажил хүлээж авсан нь шалтгаалжээ.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 258,081.0 мянган төгрөг ба тайлант хугацаанд улсын төсвийн хөрөнгөөр эм боох материал 500.0 мянган төгрөг, бичиг хэргийн материал

3,498.0 мянга, аж ахуйн материал 2,751.0 мянга, сэлбэг хэрэгсэл 2,358.0 мянга, түлш шатах тослох материалд 2,908.1 мянга, бусад хангамжийн материалд 41,672.8 мянга нийт 53,687.9 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор авч, 77,045.8 мянган төгрөгийн зарцуулалт хийж бараа материал дансны үлдэгдэл 234,723.1 мянган төгрөг болж өмнөх оноос 23,357.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 16,292,933.2 мянган төгрөг болж 129,561.0 мянган төгрөгөөр буурсан нь номын фондыг 425.0 мянган төгрөгөөр өсгөснөөс болон тайлант хугацаанд 129,986.0 мянган төгрөгийн элэгдэл байгуулснаас шалтгаалжээ.

Биет бус хөрөнгө 1,415,350.5 мянган төгрөг болж, 303,136.3 мянган төгрөгөөр өссөн нь өөрийн өмчлөлийн газар шүүхээр шийдвэрлүүлж авсан нь шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 2,617.9 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны байгууллагад өгөх өглөг, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг бүрэн барагдуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 18,091,847.5 мянган төгрөг болж 173,958.2 мянган төгрөгөөр өссөн нь засгийн газрын санг газрын эзэмших эрх шүүхээр шийдвэрлэгдсэнээр 304,566.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн, тайлант хугацааны үр дүн 130,608.1 мянган төгрөгөөр буурсан зэргээс шалтгаалжээ.

Богд хааны ордон музейн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 338,443.2 мянган төгрөгөөр буюу 40.3 хувиар буурсан нь цар тахалтай холбоотойгоор үйл ажиллагааны орлого олох боломж хомсдолтой байснаас шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 207,696.0 мянган төгрөгөөр буюу 24.7 хувиар буурсан нь мөн ковид-19 цар тахалтай холбоотойгоор үйл ажиллагааны цар хүрээ хумигдсантай холбоотой.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 438,626.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 438,626.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 428,314.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 50 арга хэмжээг санхүүжүүлэхээр 438,626.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 438,626.9 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 428,314.3 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд цалин, нийгмийн даатгалын шимтгэлд 263,456.4 мянган төгрөг зарцуулж гүйцэтгэлээр 95.7 хувь, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 33,393.0 мянган төгрөг зарцуулж гүйцэтгэлээр 74.7 хувь, хангамжийн бараа материалын зардалд 14,349.0 мянган төгрөг зарцуулж гүйцэтгэлээр 98.0 хувь, нормативт зардалд 1,432.8 мянган төгрөг зарцуулж гүйцэтгэлээр 100 хувь, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 79,521.3 мянган төгрөг, нийт 89.8 хувийн гүйцэтгэлтэйгээр 393,900.6 мянган төгрөгийг зарцуулж 34,413.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс 50,000.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 22,481.9 мянга, нийт 72,481.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Дээрх орлогыг манж цавын тогооны асар бариулахад 50,000.0 мянган төгрөг, урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлэх үйл ажиллагааны зардалд 21,779.1 мянган төгрөг тус тус зарцуулж, 702.8 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 173 мэдээллээс хугацаандаа оруулсан 133 мэдээлэл, хугацаа хоцроосон 40 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 7,889.8 мянган төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	7,889.8	2	7,889.8	-	-	-
Нийт дүн	2	7,889.8	2	7,889.8			

Улирлын чанартай ажилладаг компаниудтай хамгийн сүүлд гүйлгээ хийх бүрд тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулах, Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2 дах заалтыг үйл ажиллагаандаа мөрдөх гэсэн нийт 7,889.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгснийг биелүүлэн ажилсан байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3,960.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж 3,960.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар залруулсан алдаа зөрчил байхгүй болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар шилэн дансны зөрчилтэй холбоотой зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудас байршуулах 173 мэдээллээс хугацаа хоцроосон 40 мэдээлэл байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Цаашид шилэн дансны тухай хуулийг дагаж мөрдөн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага хүргүүлэх.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 3,960.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Цар тахалтай холбоотойгоор тухайн байгууллагад очиж хөрөнгийн хадгалалт хамгаалалт, хөрөнгийн хэсэгчилсэн тооллого хийгээгүй тул цаашид хөрөнгийн ашиглалтын хугацаа, хадгалалт, хамгаалалтын талаар дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Нийт ажил гүйлгээнээс түүвэрлэн үзэхэд цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй 2,940.0 мянган төгрөгийн худалдан авалтын гүйлгээ байгаа нь Иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 *Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 *Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*, 14 дүгээр зүйлийн 14.3-т Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

1.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг үргүй зарцуулах, шамшигдуулах

1.3. Өгсөн зөвлөмж:

Татварын ерөнхий хуулийн 28.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 14.3 дэх заалтуудыг дагаж мөрдөж ажиллах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

2.Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Автомашинны 1,020.0 мянган төгрөгийн сэлбэг солихтой холбоотой техникийн паспорт хөтлөөгүй тул техникийн шаардлагад нийцсэн эсэх нь тодорхойгүй, хянаж баталгаажуулаагүй Иж бүрэн байх, Үнэн зөв байх батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т *“үнэн зөв байх”*, 13 дугаар зүйлийн 13.1-т *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”*, 14 дүгээр зүйлийн 14.3. *“Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ”* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг зориулалтын бус ашиглах, зарцуулах

2.3. Өгсөн зөвлөмж:

Холбогдох заавар журмын дагуу авто машины засвар хийхэд техникийн акт цаг тухай бүрд нь бодож байх

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Богд хааны ордон музейн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/44/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Богд хааны ордон музей		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	5
1	Шилэн дансны хуулийн дагуу 173 мэдээлэл оруулахаас 40 мэдээлэл хугацаа хоцроосон	0.0	Албан шаардлага	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Ц.Эрдэнэбаатар Б.Эрдэнэчимэг
2	И баримтаар баталгаажуулаагүй анхан шатны баримтаар гүйлгээ хийсэн	2,940.0	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Б.Эрдэнэчимэг
3	Автомашин сэлбэг сольсонтой холбоотой техникийн паспорт бөглөөгүй	1,020.0	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Б.Эрдэнэчимэг
ДҮН		3,960.0			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 159/АД/60058

Улаанбаатар хот

САГ-2021/44/СТА-ТШБ
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Богд хааны ордон музейн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудас байршуулах 173 мэдээллээс хугацаа хоцроосон 40 мэдээлэл байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж мэдээллийг ил тод, цаг хугацаанд нь бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Богд хааны ордон музейн захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Эрдэнэбаатар, нягтлан бодогч Б.Эрдэнэчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ
ГЭРЭЛТ ХӨХИЙН ТЭНЦВЭР АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Д.БААТАРСАЙХАН

